



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/31


Улаанбаатар хот

Г Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Баасанпүрэв/-т даалгасугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
**2023** оны **02** сарын **10**-ны өдрийн **10**-дугаар  
 тушаалтын хавсралт

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
 2023 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Дотоод аудитаар хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан хаагч
1.	“Эрчис ойл” ТӨХХХК-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	2 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Д.Батнайрамдал
2.	АМГТГ-т 2022 онд хийсэн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	3 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Д.Болортuya Д.Батнайрамдал Ж.Энхсайхан
3.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэсэн байдалд дотоод аудит хийх	3 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Д.Батнайрамдал
4.	Газрын тосны хайгуул, ашиглалтын талбайн өртөг нөхөгдөх зардлын хяналтад дотоод аудит хийх	5 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Д.Болортuya Д.Батнайрамдал Ж.Энхсайхан
5.	ҮҮХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд аудит хийх	9 дүгээр сард	Х.Цэнд-Аюуш
6.	Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	10 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Д.Болортuya Д.Батнайрамдал Ж.Энхсайхан
7.	ҮҮХҮЯ-ны худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх	12 дугаар сард	Х.Цэнд-Аюуш
8.	Шаардлагатай тохиолдолд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус аудитыг хийж гүйцэтгэх	тухай бүр	Х.Цэнд-Аюуш Д.Болортuya Д.Батнайрамдал Ж.Энхсайхан